
ВИДЕО МЭДЭЭ · 2021 оны 4-р сарын 22

А.АРИУНЗАЯА: ЭРХ ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ



А.АРИУНЗАЯА: ЭРХ ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ



Сэлэнгэ аймгийн прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих ахлах прокурор А.Ариунзаяа

Түлхүүр үгс: хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль дахь зохицуулалт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөл, эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх явц дахь хүний эрхийн зөрчил.

Товч агуулга: Монгол улс нь Нэгдсэн Үндэсний байгууллагын гишүүн улс болохын хувьд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, журмыг өөрийн хууль тогтоомжийн хүрээнд хуульчлахдаа Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид заасан зарчимд нийцүүлэх үүрэг хүлээсэн.

2017 оны 07 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн Тавдугаар бүлэгт эрх хязгаарлах арга хэмжээг хуульчилсан ба зөрчлийг шуурхай шалгаж, улмаар зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн байна.

Эрх хязгаарлах арга хэмжээг хуульд заасан 4 төрлөөр хэрэгжүүлэх явцад хүний эрхийг зөрчиж болзошгүй тул уг ажиллагааны явц дахь зөрчил, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх саналыг тусгав.

Оршил

Хүний эрхийг хязгаарлаж болно, гэхдээ зайлшгүй нөхцөл байдал үүссэн үед эсвэл бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор зөвхөн хуульд зааснаар хязгаарлах нь угтаа бол хүний эрхийг хангах гол зарчим болдог. Хуульд заасны дагуу хүний эрхийг хязгаарлахдаа:

Хүний эрхийг эдлэхэд тавих хязгаарлалт нь хүний эрхийн талаарх пактуудтай нийцсэн бөгөөд хязгаарлалт тогтоосон үеэс хүчин төгөлдөр болох нийтлэг үйлчлэх үндэсний хуулиар хангаагүй бол байж болохгүй, хүний эрхийг эдлэхэд тавих хязгаарлалтыг тогтоосон хууль тогтоомж нь дур зоргын эсвэл учир шалтгаангүй байж болохгүй, хүний эрхийг хязгаарлаж байгаа эрх зүйн дүрэм журам нь хүн бүрт илэрхий, хүртээмжтэй байх, хүний эрхийн хязгаарлалтыг хууль бус эсвэл зүй бусаар тогтоох буюу ашиглахын эрэг зохистой

аюулгүй хамгаалал, үр нөлөөтэй нөхөн сэргээх арга хэмжээг хуулиар хангах[1] шаардлагыг бүрнээ хангасан байх ёстой.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлд зааснаар бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрөх, ёс суртахууны шаардлага, нийгмийн хэв журам, сайн сайхныг хангах зорилгоор төрөөс хуульчлан хүний эрхийн зарим хязгаарлалтыг тогтоож болно. Халдашгүй чөлөөтэй байх эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүний эрхийн тухай Европын конвенц, Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын пакт болон үндэсний хууль тогтоомжуудаар баталгаажуулсан юм.

Үндсэн хэсэг

Хүн өдөр тутмын амьдралдаа нийгмийн харилцаанд оролцох ба ингэхдээ тодорхой дэг журмыг мөрдөж, эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Үүрэг хүлээлгэсэн эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-д “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаар гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд ч болов эрүү шүүлт тулгаж хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” хэмээн заасан нь эрх, эрх чөлөөг зөрчихгүй байхад гол зорилго нь оршино.

Төрөөс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийгмийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд тодорхой албадлагыг хэрэгжүүлэх бөгөөд эрх зүйн дэг журмыг тогтоон хангах үйл ажиллагааны арга хэмжээ, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд зохих шийтгэлийг хүлээлгэдэг байх нь үндсэн хуульт, ардчилсан нийгмийн үндэс суурь болохын хувьд гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулж, зөрчил үйлдсэн хүнд зохих шийтгэлийг хүлээлгэнэ.

Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлах талаар өмнө болон одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй захиргааны зөрчлийн хууль тогтоомжийн хүрээнд дараахь байдлаар хуульчлан тогтоосон байна.

1992 оны 12 сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилсэн Захиргааны хариуцлагын тухай хууль	2017 оны 07 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчлийн тухай хууль
1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.	1.1 дүгээр зүйл. Хуулийн зорилго 1.Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

Захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад салбарын 220 гаруй хуулиар тогтоосон зөрчилд хариуцлага хүлээлгэдэг байсныг Зөрчлийн тухай

[1] Хүний эрхэд суурилсан хандлага.Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс. Улаанбаатар хот. 2016 он.

хуульд төрөлжүүлэн нэгтгэж, ямар үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгосон тохиолдолд тухайн үйлдэл, эс үйлдэхүйд аливаа хариуцлага хүлээлгэхгүйгээр хүн, хуулийн этгээдийн эрх зөрчигдсөн хэвээр үлддэг зэрэг байдлыг засч, хууль тэгш, шударгаар үйлчлэх, хариуцлага гарцаагүй байх зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн гэх мэт олон давуу талыг дурьдаж болно.

Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэхдээ түүний процессын хуульд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулах ба үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил мөн эсэхийг тогтоохын тулд шуурхай шалгах, зөрчил үйлдсэн хүнд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг хангах зорилгоор эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2017-2020 оны байдлаар эрх хязгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтнууд хэрэгжүүлсэн талаарх тоон мэдээний[2] үзүүлэлт:

Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал

Он	Хүний г саату улах	Бар имт бич иг хура ан авах	Үйл ажилл агаа, ашигла лтыг түр зогсоо х	МУ-ын хилээр гарах эрхийг түр түдгэлз үүлэх	Бүг д
20 17	3543	214 7	87	1	577 8
20	4150	738	242	2	117
18		9			83
20 19	4569	820 5	323	5	131 02
20 20	2886	616 1	118	-	915 0

Тоон мэдээнээс үзэхэд хүнийг саатуулах, баримт бичиг хураан авах, МУ-ын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх эрх хязгаарлах арга хэмжээг цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлсэн бол үйл ажиллагаа ашиглалтыг нь бүрэн болон хэсэгчлэн зогсоох арга хэмжээг мэргэжлийн хяналтын улсын байцаагч тус тус хэрэгжүүлсэн байна.

Эрх хязгаарлах арга хэмжээ нь албадлагын шинжтэй арга хэмжээ тул зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг шалгах явцад хуулиар хамгаалагдсан эрхэнд халдах, эрхийг нь үндэслэлгүйгээр хязгаарлах явдал гарч болзошгүй тул эрхийг нь хязгаарлахдаа тодорхой хууль, журмыг баримтална.

Хүнийг саатуулж эрхийг нь хязгаарлахтай холбоотой хуулийн зохицуулалтын харьцуулалт

Захиргааны хариуцлагын тухай хууль	Зөрчлийн тухай хууль
13 дугаар зүйл.Зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар албадан саатуулах. 1.Зөрчлийг таслан зогсоох, зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэх үед шаардлагатай гэж үзвэл зөрчил гаргасан этгээдийг сумын Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах захиргааны журмаар албадан	5.2 дугаар зүйл. Хүнийг саатуулах. 1.Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан үндэслэл, хугацаагаар хүнийг саатуулна: 1.1.Тагнуулын болон цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч

[2] Улсын ерөнхий прокурор газрын жилийн эцсийн хяналтын ажлын тоон мэдээ.2017-2020 он.

саатуулж болно. 3.Зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар түр саатуулах хугацаа 6 цагаас илүү байж болохгүй. 4.Зөрчил гаргасан этгээдийг ноцтой хор уршиг бий болгоход хүргүүлэхгүй байх зайлшгүй шаардлагатай тохиолдолд харьяалах шүүхэд албан ёсоор мэдэгдэж түүнийг 72 цаг хүртэл хугацаагаар захиргааны журмаар албадан саатуулж болно. Улсын хилийн дэглэм зөрчигчийн хувийн байдлыг нотлох баримт бичиггүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлтэйгөөр 10 хоног хүртэл хугацаагаар саатуулж болно. 13[1] дүгээр зүйл. Зарим этгээдийг захиргааны журмаар албадан саатуулах онцлог 1.Согтуурах, мансуурах донтой, түүнчлэн сэтгэцийн өвчтэй буюу биеийн байцаалт тодорхойгүй этгээд зөрчил гаргасан бол тэдгээрийг цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан 72 цаг хүртэл хугацаагаар албадан саатуулж болно.	холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор 6 цаг хүртэл хугацаагаар; 1.2.цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч зөрчил үйлдсэн согтуурсан, мансуурсан холбогдогчийг 24 цаг хүртэл хугацаагаар; 1.3.хилийн төлөөлөгч, орлогч, туслах хилийн дэглэм зөрчсөн хүний хувийн байдлыг тогтоох зорилгоор 7 хүртэл хоногоор; 1.4.гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн гаргасан хүсэлтээр холбогдогчийн хувийн байдлыг тогтоох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ажиллагаанд саад учруулж болзошгүй бол эрүүгийн хэргийн шүүх тухайн гадаадын иргэн, харъялалгүй хүнийг 14 хүртэл хоногийн хугацаагаар; 9.1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа 4.Холбогдогч оргон зайлах, эсхүл дахин зөрчил үйлдэж болзошгүй тохиолдолд прокурорт мэдэгдэж 24 цаг хүртэлх хугацаагаар саатуулж болно. Шаардлагатай бол энэ хугацааг харъяалын шүүхийн зөвшөөрлөөр 48 хүртэл цагаар нэг удаа сунгаж болно.

Зөрчил: Түр саатуулах ажиллагааны явцад өмнө нь түр саатуулах байрнаас гадуур хэрэгжүүлж байжээ./ажлын өрөөнд, паарнаас гавлах, коридор, машин гэх мэт/

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар хүнийг саатуулах эрх бүхий албан тушаалтан, хугацаа, үндэслэлийг илүү тодорхой зохицуулсан, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан тушаалаар баталсан эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл журмыг нэг стандарт шаардлагаар журамласан боловч хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд дараахь зөрчлүүд гарч байна. Тухайлбал:

Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь хүлээн авч, шалгах явцад зөрчлийн холбогдогчийг эрүүлжүүлэх байранд хүлээлгэн өгч, эрүүлжүүлсэн хүний тэмдэглэл үйлддэг.

2003 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр батлагдсан Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсоны улмаас хаана байгаагаа болон очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасан, энэ байдлаас болж өөрөө осол, гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй болсныг үндэслэл болгон цагдаагийн алба хаагч тухайн этгээдийг хамгаалах, тусламж үзүүлэх зорилгоор эрүүлжүүлэх байранд хүлээлгэн өгнө” гэж заасан.

Гэтэл согтуугаар гэх тодотголтой аливаа дуудлага мэдээллийн холбогдогчид Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-д зааснаар согтуурсан, мансуурсан хүнийг саатуулах тогтоол

үйлдэлгүйгээр танхайрсан, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон бусад согтуугаар үйлдсэн гэх зөрчлийн дуудлага мэдээлэлд хавтгайруулан эрүүлжүүлэх тэмдэглэл үйлддэг байдал нийтлэг байгаа юм.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлд заасан зарим зөрчлийг тусгай журмаар шалган шийдвэрлэж, шүүхээс баривчлах шийтгэл оногдуулж болох зөрчлийн холбогдогчид хүнийг саатуулах тухай тогтоол үйлддэггүйгээс эрүүлжүүлэгдсэн хугацааг цаашид баривчлах хугацаанд оруулан тооцох боломжгүй болж, Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 7 дахь хэсэг “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед саатуулагдсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцно” гэх заалт зөрчигдөж байна.

Үүний эсрэгээр согтуурсан, мансуурсан үедээ зөрчил үйлдсэн гэх үндэслэлээр саатуулах тогтоол үйлдсэн боловч тухайн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шалгаад эцэст нь зөрчлийн шинжгүй гэх үндэслэлээр татгалзан хааж байгаагаас үзэхэд үндэслэлгүйгээр саатуулсан тухай асуудал үүсч байгааг анхаарах шаардлагатай.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслахаас хүнийг саатуулах эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байна. Өөрөөр хэлбэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчлийн холбогдогчийг саатуулах эрхийг олгосон, эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл журмыг баталсан, мөн саатуулах байрны дэглэм, журам нэгэнт батлагдаад даруй 4 жилийн хугацаа өнгөрч байхад хилийн боомт бүхий зарим аймгуудад саатуулах байр байхгүй байна. Энэ тохиолдолд хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслахууд хилийн дэглэм зөрчсөн хүний хувийн байдлыг тогтоохын тулд саатуулах байрнаас гадуур, үндэслэлгүйгээр эрхийг нь хязгаарлах явдал гарч болзошгүй байна.



Тухайлбал Сэлэнгэ аймагт өнөөдрийг хүртэл саатуулах байхгүй тул саатуулах байрны асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байгаа юм.

Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээн байгаа орчинд шууд эсхүл шууд бусаар хор хохирол учруулж байгаа, эсхүл учруулж болох нөхцөл байдал үүссэн үед холбогдогчийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн, эсхүл барилга байгууламж, машин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг прокурорын зөвшөөрлөөр түр зогсооно.

Эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй тохиолдолд дээрх арга хэмжээг авч, прокурорт даруй мэдэгдэх хуулийн зохицуулалттай.

Ихэнх тохиолдолд уул уурхайн компаниуд нь техник эдийн засгийн үзүүлэлтийн дагуу үйл ажиллагаа явуулдаггүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан

ажлуудыг хугацаанд нь хийгээгүй, дотоод хяналт шалгалт зохион байгуулах журамгүй, мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн албан шаардлагыг биелүүлдэггүй, удаа дараа зөрчсөн, комиссын актгүйгээр олборлолт явуулсан, овоолго даланд үүссэн хагарал, нурлыг илрүүлэх, аюулгүй болгох арга хэмжээ авдаггүйгээс хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах, осол гарах, хүний эрүүл мэнд, амь нас хохирох эрсдэл бий болгосон зэрэг үндэслэлээр хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан байна.

Уг эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад эрх бүхий албан тушаалтнууд нь гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг эргэж тооцолгүй хэрхэх нь тодорхойгүй байдгаас зарим тохиолдолд хүн, хуулийн этгээдэд эд хөрөнгө, эдийн засгийн хохирол учирч болзошгүйг анхаарах шаардлагатай байна.

Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг хангахад зайлшгүй шаардлагатай гэж үзвэл холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, улсын хил нэвтрэх эрхийн баримт бичиг, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл зэрэг баримт бичгийг хураан авна.

2017, 2018, 2019 онуудад цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөрчлийн холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх хураан эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлсэн бол 2020 онд улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас баримт бичиг хураан авах эрх хязгаарлах арга хэмжээг нэг л удаа хэрэгжүүлжээ.

Түүнчлэн эрх бүхий албан тушаалтан зөрчлийн холбогдогчийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад саад учруулж болзошгүй нөхцөл байдал тогтоогдвол Монгол улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх саналыг прокурорт гаргаж, прокурор үндэслэлтэй гэж үзвэл тогтоол үйлдэн эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

Тэгвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлд “яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол улсын хилээр гарахыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ” гэж заасан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.5 дугаар зүйлд прокурор зөрчил шалгах ажиллагаанд саад учруулж болзошгүй талаарх эрх бүхий албан тушаалтны саналыг гэж үзвэл Зөрчлийн тухай хуульд арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх, эсвэл хөрөнгө, орлого, хохирлын тодорхой хувиар тооцсон торгох шийтгэлийн хэмжээ нь арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд холбогдогчийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлж болохоор хуульчилсан.

Дээрх хоёр зохицуулалтаас үзэхэд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татагдсан тохиолдолд шүүхийн

шийдвэрээр, арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэй зөрчлийн хэргийн холбогдогчийг прокурорын шийдвэрээр түр түдгэлзүүлэхээр субъектийг ялгамжтай хуульчилсан байх боловч Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг зөрчсөн гэж үзэхээр байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ямар ч гэмт хэргийг үйлдсэн хүнийг тухайлбал дөрвөн зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн яллагдагчийн хилээр гарах эрхийг нь хязгаарлаж болох бол арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулах зөрчлийн холбогдогчийг хилээр гарах эрхийг мөн л түдгэлзүүлж болохоор тус тус заасан, мөн эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ангиллаас үл хамаарч эрхийг нь хязгаарлаж болохоор хуульчилсан бол зөрчлийн тухай хуулинд заасан зөвхөн арван мянган нэгжээс дээш төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчлийн холбогдогчийн хилээр гарах эрхийг түдгэлзүүлэхээр хуульчилсан зэргээс тодорхой харагдахаар байна.

Дүгнэлт

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл журмыг тодорхойлж, зөрчлийг шуурхай, хэвийн явуулах нөхцлийг хангах хөшүүрэг, дэмжлэг үзүүлэх зохицуулалтууд батлагдан гарсан хэдий ч эрхээ хязгаарлуулж байгаа хүн бүр бурууган биш гэдгийг онцгой анхаарахын зэрэгцээ эрх, эрх чөлөөг нь үндэслэлгүйгээр хязгаарлахгүй байхад эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд прокуророос зохих хяналтыг тавих шаардлагатай байна. Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хүний эрхийг хангах талаар дараахь 3 саналыг гаргаж байна. Үүнд:

1.Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд хүнийг саатуулах эрх хязгаарлах арга хэмжээг хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэгжүүлэх.

2.Зарим хилийн боомт бүхий газруудад саатуулах байр бий болгох асуудлыг яаралтай шийдвэрлэх.

3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан “Монгол улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх” эрх хязгаарлах арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулинд заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэснийг зөрчиж байх тул хуулийн дээрх зохицуулалтыг анхаарах шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улсын Үндсэн хууль.
2. Монгол Улсын Зөрчлийн тухай хууль.
3. Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль.
4. Монгол улсын Хилийн тухай хууль. УБ. 2016 он.
5. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, үзэл баримтлал.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2869